



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/199/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Ц.Мөнхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: munkhtuyats@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Си Пи Ти Эй Аудит" ХХК
Захирал: Ч.Энхчимэг
Цахим хаяг: info@cptaaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН
ДАРГА Д.ОТГОНСҮРЭН ТАНАА

2022.02.25 № 07/409
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойжин ламын сүм музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichigi\2022\0225 Auditlin 2 Газар - 61.Docx

001050448

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56,987,411.34	66,240,790.00
33	АВЛАГА	4,436,615.34	15,827,420.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	466,569.34	56,120.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	600,446.00	-
335	Бусад авлага	3,369,600.00	15,771,300.00
3351	Байгууллагаас авах авлага	3,369,600.00	15,771,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,550,796.00	50,413,370.00
354	Хангамжийн материал	52,550,796.00	50,413,370.00
35410	Бичиг хэргийн материал	11,637,748.00	10,366,712.00
35420	Аж ахуйн материал	12,758,518.00	15,927,598.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,169,000.00	2,988,790.00
35470	Бусад хангамжийн материал	25,985,530.00	21,130,270.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,968,313,599.11	4,923,619,658.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,968,313,599.11	4,923,619,658.65
392	Биет хөрөнгө	4,310,713,599.11	4,266,019,658.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	291,812,104.90	291,812,104.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,363,425.40)	(66,414,705.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	193,714,843.33	204,003,043.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(165,543,863.80)	(179,211,795.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,441,109.00	59,240,979.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,448,160.04)	(32,149,163.41)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,954,292,959.00	3,954,292,959.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,961,652.52	45,961,652.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,037,540.40)	(14,075,080.80)
39217	Ном	1,883,920.00	2,559,665.00
393	Биет бус хөрөнгө	657,600,000.00	657,600,000.00
39301	Програм хангамж	990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(990,000.00)	(990,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	657,600,000.00	657,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,025,301,010.45	4,989,860,448.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,802,230.19	650,297.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,802,230.19	650,297.50
413	Өглөг	1,802,230.19	650,297.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,802,230.19	466,169.50
4136	Бусад өглөг	-	184,128.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	184,128.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,023,498,780.26	4,989,210,151.15
51	Засгийн газрын хувь оролцоо	5,023,498,780.26	4,989,210,151.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,906,414,021.00	1,906,414,021.00
51101	Өмч: - төрийн	1,906,414,021.00	1,906,414,021.00
512	Хуримтлагдсан үр дүн	580,676,122.52	546,387,493.41
51210	Өмнөх үеийн үр дүн	580,676,122.52	580,676,122.52
51220	Тайлант үеийн үр дүн	-	(34,288,629.11)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,536,408,636.74	2,536,408,636.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,025,301,010.45	4,989,860,448.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	370,501,000.00	436,481,035.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,403,100.00	3,683,385.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,403,100.00	3,683,385.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,403,100.00	3,683,385.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,403,100.00	3,683,385.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	358,097,900.00	432,797,650.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	341,456,400.00	345,482,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	341,456,400.00	345,482,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,641,500.00	87,314,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	49,228,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,641,500.00	38,086,850.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	410,753,632.75	470,769,664.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	410,753,632.75	470,769,664.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,463,531.93	460,735,740.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,699,657.60	230,340,731.71
210101	Үндсэн цалин	178,941,570.60	173,317,631.71
210102	Нэмэгдэл	30,238,376.00	31,265,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,979,716.00	25,758,000.00
210104	Урамшуулал	3,539,995.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,984,828.25	30,871,399.01
210201	Тэтгэврийн даатгал	19,970,444.42	22,111,326.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,349,464.03	2,365,289.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,778,771.22	1,800,503.75
210204	Ажилгүйдлийн даатгал	439,220.53	450,126.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,446,928.05	4,144,153.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,325,890.60	16,852,982.00
210301	Гэрэл, цахилгаан	16,355,517.60	15,944,103.00
210303	Цэвэр, бохир ус	970,373.00	908,879.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,392,676.18	38,903,704.00
210401	Бичиг хэрэг	11,145,853.00	15,581,496.00
210402	Тээвэр, шатахуун	2,718,400.00	1,811,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	624,985.00	672,768.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,660,500.00	1,815,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,242,938.18	13,008,770.00
210408	Бараа материал акталсны зардал	-	6,013,970.00
2105	Нормативт зардал	60,000.00	41,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,000.00	41,000.00
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	-
210702	Дотоод албан томилолт	900,000.00	-

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,573,896.00	86,268,168.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,351,267.00	77,994,668.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,800,000.00	2,800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	999,400.00	1,273,500.00
210807	Газрын төлбөр	4,199,580.00	4,200,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	223,649.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,526,583.30	57,457,755.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,365,330.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,161,253.30	57,457,755.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,290,100.82	10,033,923.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	4,328,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	4,328,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,290,100.82	5,705,923.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,290,100.82	3,393,059.63
213305	Нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлсэн шилжүүлэг	-	2,312,864.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(40,252,632.75)	(34,288,629.11)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,810,217.90	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,810,217.90	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,810,217.90)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(52,062,850.65)	(34,288,629.11)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,546,117,750.34	623,029,859.57	5,075,561,630.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	9,709,113.60	9,709,113.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,906,414,021.00	2,546,117,750.34	632,738,973.17	5,085,270,744.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(9,709,113.60)	-	(9,709,113.60)
Тайлант үеийн үр дүн	-	-	(52,062,850.65)	(52,062,850.65)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	580,676,122.52	5,023,498,780.26
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	580,676,122.52	5,023,498,780.26
Тайлант үеийн үр дүн	-	-	(34,288,629.11)	(34,288,629.11)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	546,387,493.41	4,989,210,151.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	358,097,900.00	433,398,096.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	358,097,900.00	433,398,096.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	341,456,400.00	345,482,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	341,456,400.00	345,482,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,641,500.00	87,915,296.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	49,228,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,641,500.00	38,687,296.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	358,097,900.00	422,964,426.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	358,097,900.00	422,964,426.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,207,353.18	412,930,502.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,496,226.00	229,874,169.37
210101	Үндсэн цалин	178,784,262.00	172,405,848.37
210102	Нэмэгдэл	30,192,253.00	31,974,321.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,979,716.00	25,494,000.00
210104	Урамшуулал	3,539,995.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,852,599.00	30,901,507.00
210201	Тэтгэврийн даатгал	17,738,437.00	21,798,189.68
210202	Тэтгэмжийн даатгал	4,078,592.00	2,342,924.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,566,107.00	1,802,651.82
210204	Ажилгүйдлийн даатгал	462,651.00	450,812.76
210205	Эрүүл мэндийн даатгал	3,006,812.00	4,506,928.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,572,154.00	18,924,682.00
210301	Гэрэл, цахилгаан	12,601,781.00	17,957,393.00
210303	Цэвэр, бохир ус	970,373.00	967,289.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,718,814.00	25,241,067.00
210401	Бичиг хэрэг	4,719,900.00	1,524,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,718,400.00	1,811,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	785,375.00	672,768.00
210404	Ном, хэвлэл	-	11,586,729.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,177,400.00	4,194,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,317,739.00	5,451,070.00
2105	Нормативт зардал	2,160,000.00	41,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,160,000.00	41,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,921,360.00	12,651,790.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,989,000.00	2,651,800.00
210602	Тавилга	1,932,360.00	-
210604	Урсгал засвар	-	9,999,990.00
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	-
210701	Гадаад албан томилолт	900,000.00	-

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,586,200.18	95,296,287.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,587,220.18	86,421,087.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,800,000.00	2,800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	999,400.00	1,875,200.00
210807	Газрын төлбөр	4,199,580.00	4,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,890,546.82	10,033,923.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	4,328,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	4,328,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,890,546.82	5,705,923.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,890,546.82	3,393,059.63
213305	Нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлсэн шилжүүлэг	-	2,312,864.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	10,433,670.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	10,433,670.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,433,670.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,433,670.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	10,433,670.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(10,433,670.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	345,482,800.00	342,089,740.37	3,393,059.63	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	345,482,800.00	342,089,740.37	3,393,059.63	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,154,800.00	341,761,740.37	3,393,059.63	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,141,000.00	225,366,654.37	1,774,345.63	99.2
210101	Үндсэн цалин	160,324,700.00	167,898,333.37	(7,573,633.37)	104.7
210102	Нэмэгдэл	57,467,400.00	31,974,321.00	25,493,079.00	55.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,348,900.00	25,494,000.00	(16,145,100.00)	272.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,474,000.00	30,257,576.00	1,216,424.00	96.1
210201	Тэтгэврийн даатгал	22,148,400.00	21,154,258.68	994,141.32	95.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,331,400.00	2,342,924.58	(11,524.58)	100.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,865,100.00	1,802,651.82	62,448.18	96.7
210204	Ажилгүйдлийн даатгал	466,300.00	450,812.76	15,487.24	96.7
210205	Эрүүл мэндийн даатгал	4,662,800.00	4,506,928.16	155,871.84	96.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,924,700.00	18,924,682.00	18.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	18,189,000.00	17,957,393.00	231,607.00	98.7
210303	Цэвэр, бохир ус	735,700.00	967,289.00	(231,589.00)	131.5
2104	Хангамж, бараа материалын зардал	8,771,500.00	8,771,178.00	322.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,129,900.00	1,524,100.00	(394,200.00)	134.9
210402	Тээвэр, шатахуун	1,602,800.00	1,511,700.00	91,100.00	94.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,483,800.00	672,768.00	811,032.00	45.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,027,600.00	2,234,700.00	792,900.00	73.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,527,400.00	2,827,910.00	(1,300,510.00)	185.1
2105	Нормативт зардал	41,000.00	41,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	41,000.00	41,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,999,990.00	10.00	100.0
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,999,990.00	10.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,802,600.00	48,400,660.00	401,940.00	99.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,217,700.00	42,028,660.00	189,040.00	99.6

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,800,000.00	2,800,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,800.00	800,000.00	800.00	99.9
210807	Газрын төлбөр	2,772,000.00	2,772,000.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	212,100.00	-	212,100.00	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	328,000.00	328,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	328,000.00	328,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	328,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	345,482,800.00	342,089,740.37	3,393,059.63	99.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	345,482,800.00	342,089,740.37	3,393,059.63	99.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	345,482,800.00	342,089,740.37	3,393,059.63	99.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	20	-	100.0
650006	Соёл урлагийн салбарын терийн йлчилгээний албан хаагч (ТҮСУ)	15	15	-	100.0
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		87,915,296.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		87,915,296.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		85,602,432.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,507,515.00
210101	Үндсэн цалин		4,507,515.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		643,931.00
210201	Тэтгэврийн даатгал		643,931.00
2104	Хангамж, бараа материалын зардал		17,983,789.00
210402	Тээвэр, шатахуун		300,000.00
210404	Ном, хэвлэл		11,586,729.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,960,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,137,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,988,570.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		10,988,570.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		47,478,627.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		44,392,427.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,658,200.00
210807	Газрын төлбөр		1,428,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		4,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,312,864.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		2,312,864.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		87,915,296.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		87,915,296.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		49,228,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		38,687,296.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварыг etax.mn татварын системд ТТ-11 маягтаар илгээхдээ санхүүгийн тайланд тусгасан дүнтэй нийцүүлэн үнэн зөв тайлагнахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн аудитор Д.Нансалмаа, аудиторын туслах Б.Бүрэнжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ч.Энхчимэг, чанарын хяналтын менежер Д.Мядагмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Чойжин ламын сүм музей 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Чойжин ламын сүм музейн эрхэм зорилго нь музейд хадгалагдаж буй Монголын түүх, шашин, соёл, уран барилга, урлахуйн ухааны дахин давтагдашгүй үнэт бүтээлийг судлан сурталчилж, сэргээн баяжуулах, хадгалан, хамгаалж, хойч үеийнхэнд уламжлуулахад оршино.

Чойжин ламын сүм музейн үйл ажиллагааны чиглэл нь музей, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа, музейн нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, сургах, хүн түүний орчинтой холбоотой бодит ба бодит бус байгаль, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, харилцан холбох байнгын үйл ажиллагаа бүхий ашгийн төлөө бус, олон нийтэд нээлттэй байгууллага байх гэж заасан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь 2021 оны 4 дүгээр улиралд Чойжин ламын сүм музейн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 21 нэр төрлийн мэдээллийг 149 талбарт мэдээлэхээс 9 талбарт хугацаа хоцроосонд зөвлөмж өгч, шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт 91.9 хувьтай байна гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чойжин ламын сүм музей 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 410,753.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,107.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Чойжин ламын сүм музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,440.6 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4,436.6	15,827.4	11,390.8
Бараа материал	52,550.8	50,413.4	(2,137.4)
Үндсэн хөрөнгө	4,968,313.6	4,923,619.6	(44,694.0)
Нийт хөрөнгө	5,025,301.0	4,989,860.4	(35,440.6)
Өр төлбөр	1,802.2	650.2	(1,152.0)
Засгийн газрын хувь оролцоо	5,023,498.8	4,989,210.2	(34,288.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,025,301.0	4,989,860.4	(35,440.6)

Авлага дансны үлдэгдэл 15,827.4 мянган төгрөг болж 11,390.8 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдаас авах авлага 56.1 мянга, Адмон ХХК-д ном хэвлэлтэд зориулж урьдчилгаа 10,000.0 мянга, УБЦТС ХК-д цахилгааны төлбөрийн урьдчилгаа 2,071.7 мянга, Юнитра ХХК-д засварын төлбөрийн урьдчилгаа 330.0 мянган төгрөг нийт 12,457.8 мянган

төгрөгөөр авлага нэмэгдэж, тайлант онд татаас санхүүжилтийн авлага 600.4 мянга, ажилчдад илүү цалин бодож олгосны авлага 466.6 мянган төгрөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 52,550.8 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд 30,931.5 мянган төгрөгийн худалдан авалт, 1,353.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал тус тус нэмэгдэж, 28,408.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, Чойжин ламын сүм музейн 2021 оны А/88 дугаар тушаалаар 6,014.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 50,413.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,923,619.7 мянган төгрөг болж, 44,693.9 мянган төгрөгөөр буурсан нь 10,433.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 2,330.1 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлж авсан, тайлант хугацааны элэгдлийн зардал 57,457.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 650.3 мянган төгрөг болж 1,151.9 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, хувь хүний орлогын албан татварт өгөх өглөгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,989,210.2 мянган төгрөг болж 35,440.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Чойжин ламын сүм музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 65,980.0 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан 3,683.4 мянган төгрөгийн хөрөнгө, дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилтээр олгосон 49,228.0 мянган төгрөгийн санхүүжилт байна.

Энэ нь “Чойжин ламын сүм музейн дурсгалт барилгын нөхцөл байдал” судалгааны ажлыг гүйцэтгүүлэх болон хэвлэх, Соёлын яамнаас санаачилсан “Цахим соёл түгээе” аяны хүрээнд зохион байгуулсан “Музей миний нүдээр” гэр бүлийн гар зургийн уралдаан зохион байгуулахад шаардлагатай зардал, тус гар зургийн уралдааны үзэсгэлэн зохион байгуулах, үзэсгэлэнгийн нээлтийн үйл ажиллагааны үеэр боловсролын ажил зохион байгуулахад шаардлагатай зардал, “Соёлын өв ба бүтээлч үйлдвэрлэл: Баялгийн зохистой удирдлага” сэдэвт хэлэлцүүлгийн бэлтгэл ажил болон зохион байгуулахад шаардлагатай зардал, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан үндэсний зорилтот арга хэмжээний хүрээнд “Соёлын салбарын цахим шилжилт” ажлын хүрээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж бэлтгэх зэрэг зардлуудын санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 60,016.0 мянган төгрөгөөр буюу 14.6 хувиар өссөн нь өмнөх оны үндсэн цалин, нийгмийн даатгалын шимтгэл 9,527.7 мянга, хангамжийн материалын зардал 13,511.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 32,694.3 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 3,328.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,021,331.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,021,331.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 675,848.9 мянган төгрөгөөр бууруулж 345,482.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь музейн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай 9 орон тоог нэмэгдүүлэх, үзэсгэлэнгийн танхим сүмүүд төвлөрсөн системд холбогдоогүй тул шалны халаалтыг шинэчлэх, дулаан алдалтыг багасгах засвар үйлчилгээ явуулах, түүх соёлын дурсгалт барилга болон үзмэр, эд өлгийн зүйлийг таниулан сурталчлах зардлыг тус тус бууруулж баталсантай холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 26 арга хэмжээг санхүүжүүлэхээр 345,482.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 345,482.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 345,482.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 342,089.7 мянган төгрөгийг зарцуулж 3,393.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 342,089.7 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,774.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1,216.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 401.9 мянган төгрөгөөр тус тус зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 3 хөтөлбөрийн 10 арга хэмжээ 3,204.5 мянган төгрөгөөр, 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээ 188.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	80101	Үндсэн үйл ажиллагаа	307,810.5	304,606.0	3,204.5	98.9
2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	7,524.3	7,335.7	188.6	97.4
3	80219	Харуул хамгаалалт	29,820.0	29,820.0	-	100.0
4	80802	Ажил олгогчоос тэтгэмж	328.0	328.0	-	100.0
Нийт дүн			345,482.8	342,089.7	3,393.1	99.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 49,228.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 38,687.3 мянга, нийт 87,915.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшуулалд 4,507.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 643.9 мянга, хангамжийн материалд 17,983.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 10,988.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажилд 47,478.6 мянга, нэг удаагийн тэтгэмж 4,000.0

мянга, нийт 85,602.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,312.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Чойжин ламын сүм музей нь 20 ажилтантай бөгөөд захиргааны, эрдэм шинжилгээ, сан хөмрөгийн нэгж, үйлчилгээ аж ахуйн нэгж гэсэн 3 нэгжээс бүрддэг.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 хөтөлбөр, 26 арга хэмжээний хэрэгжилт 99.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.0 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төсөл боловсруулахдаа төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогыг төлөвлөөгүй дээд шатны төсөв захирагч хянахдаа ч нэмж баталж өгдөггүй байна.

Сүүлийн 3 жилийн музейн өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогуудыг жагсаавал:

2019 онд 78,253.0 мянга, 2020 онд 16,641.5 мянга, 2021 онд 38,086.9 мянган төгрөг байна. Үйл ажиллагааны орлого сүүлийн 2 жилд огцом буурсан нь ковид 19 өвчний нөхцөл байдлаас шалтгаалсан. Дээрх орлогуудыг 2019 онтой харьцуулахад 2020 онд 78.7 хувиар, 2021 онд 51.3 хувиар тус тус буурсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Чойжин ламын сүм музейн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 21 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Чойжин ламын сүм музейн тайлант онд шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 149 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг хэрэгжүүлж 7,849.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол холбогдох заалтууд нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 28,571.8 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрсэнд залруулах зөвлөмж өгсөн, жилийн эцсийн аудитаар дахин хянахад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 33,606.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 33,606 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг биелүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	33,606.0	4	33,606.0	-	-	100
Зөвлөмж	1	-	1	-	-	-	100
Нийт дүн	5	33,606.0	5	33,606.0	-	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Соёлын үнэт өв хөрөнгийг санхүүгийн тайланд багцаар нь түүх соёлын дурсгалт зүйл нэрийн дор нийт 1,001 дэсийн 6,384 ширхэг, 3,893,051.9 мянган төгрөгийн үзмэрийг нэг ширхгээр бүртгэсэн байна. Энэхүү 6,384 ширхэг үзмэр Соёлын өвийн мэдээллийн сангийн программ хангамжид дэлгэрэнгүйгээр бүртгэгдсэн гэх боловч тус байгууллагын санхүүгийн программд ашиглаж байгаа хөрөнгийн бүртгэлд дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна. Энэ нь толилуулга ба тодруулга, Нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй тул санхүүгийн тайланд үзмэр тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэх шаардлагатай ба дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

Тус байгууллагын газрын гэрчилгээ Чойжин ламын сүмийн нэр дээр байгаа боловч хойд талын 800 м.кв талбайг Чоно ХХК тохижуулан, ашиглаж байгаагаас гадна тохижилтын төлбөрийг Чойжин лам музейгээс нэхэмжилсэн шүүхийн маргаантай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 84,572.9 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 84,515.3 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 57.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 57.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 4,107.5 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Цахим баримтын ebarimt.mn системд шивэгдсэн баримтыг мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын баримтуудтай тулгахад 10,467.0 мянган төгрөгийн и баримт дутуу байсныг нөхөж шивүүлсэн;
- Цалингийн тооцооллыг давтан тооцоолоход санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 644.0 мянган төгрөгөөр илүү, Нийгмийн даатгалын шимтгэлийг зардлыг 599.9 мянган төгрөгөөр дутуу, Нийгмийн даатгалын тайланд 9, 11 саруудад 17 кодоор тайлагнах ёстой ажилтанг 06 кодоор тайлагнасан байсныг залруулсан;
- Нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн 72,620.3 мянган төгрөгийг кассанд давхар бүртгэснийг залруулсан;
- Ажил гүйцэтгэх А/Г-03 дугаартай гэрээний үйлчилгээний төлбөрийг барагдуулахдаа татварын суутгалыг буруу тооцоолон 184.1 мянган төгрөг дутуу олгосныг санхүүгийн байдлын тайланд тусгаж залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланг 57.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Нийцсэн бөгөөд зохистой байх”, Татварын ерөнхий хуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-д “суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Зөвлөмж:

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланг үнэн зөв тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Чойжин ламын сүм музей	АХГ-2022/199/НА-СТА-ТШЗ	Цахим баримтын ebarimt.mn системийн баримтууд дутуу шивэгдсэн зөрчил илэрсэн.	ebarimt.mn системд баримтыг нөхөн авсан.	1	10,467.0	1	10,467.0						
2	Чойжин ламын сүм музей	АХГ-2022/199/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг илүү, дутуу тайлагнасан зөрчил илэрсэн.	Цалингийн зардал, нийгмийн даатгалын зардлыг зөв дүнгээр тусгаж, нийгмийн даатгалын тайланг залруулав.	1	1,243.9	1	1,243.9						
3	Чойжин ламын сүм музей	АХГ-2022/199/НА-СТА-ТШЗ	Нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн 72,620.3 мянган төгрөгийг кассанд давхар бүртгэсэн зөрчил илэрсэн.	Давхар бүртгэсэн дансны бичилтийг залруулав.	1	72,620.3	1	72,620.3						
4	Чойжин ламын сүм музей	АХГ-2022/199/НА-СТА-ТШЗ	Ажил гүйцэтгэх гэрээний үйлчилгээний төлбөрийг барагдуулахдаа татварын суутгалыг буруу тооцоолон суутгасан зөрчил илэрсэн.	Санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийг тусгав.	1	184.1	1	184.1						
5	Чойжин ламын сүм музей	АХГ-2022/199/НА-СТА-ТШЗ	Санхүү ба татварын тайлангаар ХХОАТ-ын тайланг зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрсэн	ХХОАТ-ын тайланг зөв дүнгээр засаж илгээх	1	57.6							1	57.6
	ДҮН				5	84,572.9	4	84,515.3					1	57.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Чойжин ламын сүм музей	АХГ-2022/199/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах;	1	-					1	-		
	ДҮН				1	-					1	-		
НИЙТ ДҮН					6	84,572.9	4	84,515.3			1	-	1	57.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 242/А0150458
АХГ-2022/199/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн системд хуулийн дагуу байршуулах 149 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Чойжин ламын сүм музейн дарга Д.Отгонсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
С НАЦАГДОРЖ
Ч ЭНХЧИМЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264236

110.10.10.20\dok\g_khreeg\Auditore Shuudlaga\2022\0225 Auditin 2 Gasee-228.docx

0010800740

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.